



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 5/04

Баянхутаг сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Соёлын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/166, А/63, А/73 тоот хамтарсан тушаал, Хэнтий аймгийн соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/420 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус соёлын төвийн дарга С.Мөнххэрлэн нь 2024 оны 4 дугаар улирлын ажлын үзүүлэлтээр 88 (наян найм) хувьтай үнэлэгдсэн тул ур чадварын нэмэгдлийг 20 (хорь) хувиар тооцож олгосугай.

2. С.Мөнххэрлэнгийн ур чадварын нэмэгдлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сар бүр тооцож олгохыг нягтлан бодогч (Х.Энхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАЙГАЛМАА



**ХЭНТИЙ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж, Баянмөнх баг, Чингис хот
Хэнтий аймаг, 23117, Утас/Факс: (976)7056-2044
Цахим шуудан: khentisoyoliinheltes@gmail.com

2024.12.26 № 1/420

танай _____-ны № _____-г

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

Соёлын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/166, А/63, А/73 тоот хамтарсан тушаалаар соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг баталсан.

Тус шалгуур үзүүлэлтийн 9 дэх заалтад "Соёл, урлагийн салбарын удирдах албан тушаалтан буюу төсвийн шууд захирагч нарын ур чадварын нэмэгдлийг Соёл, урлагийн газрын дарга үнэлж, дүгнэн шийдвэрлэнэ" гэж заасан тул тус газраас хүргүүлсэн үнэлгээний хуудсыг үндэслэн ур чадварын нэмэгдэл олгох шийдвэрийг гаргаж журмыг хэрэгжүүлж ажиллана уу.

Хамтарсан тушаал болон ур чадварыг үнэлсэн үнэлгээний дүнг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ **Т.ЗУЛБААТАР**



ШТМ5703 4203402 1824090045

Хэнтий аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын
газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны
өдрийн 1/420 дугаар албан бичгийн хавсралт

Баянхутаг сумын Соёлын төвийн дарга С.Мөнххэрлэнгийн
2024 оны 4 дүгээр улирлын үр чадварын үнэлгээ

2024.12.25

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1.	Манлайлах чадвар	Ажилтны үр бүтээлтэй ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал	8	42
		Үйлчлүүлэгчийн тав тух, соёлын хүртээмж орон зай, уран бүтээлийн чанар сэтгэл ханамжийг бүрдүүлсэн байдал	10	
		Авьяас билэг, үр чадвар, мэргэжлийн туршлагаар манлайлсан байдал	8	
		Хамт олны төлөвшил, байгууллагын соёлд гарсан өөрчлөлт	6	
		Төсөв санхүү, эд хөрөнгийн зөрчилгүй байх	10	
2	Мэргэжил арга зүйн чадвар	Мэдлэг, туршлага хуваалцах чадвар	10	30
		Эрхлэсэн ажил үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн байдал	10	
		Ажилтны мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт	10	
3	Ажлын арга барил асуудал шийдвэрлэх чадвар	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, асуудал шийдвэрлэсэн байдал	8	16
		Соёлын үйлчилгээний хүртээмжид гарсан, ахиц, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл	8	
	Нийт үнэлгээ			88 /20%/

60-69 оноо	70-79 оноо	80-89 оноо	90-100 оноо
10%	15%	20%	25%

АЙМГИЙН СУАЖЗГ-ЫН ДАРГА



Т.ЗУЛБААТАР